

**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь: компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээр асуудлаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН:

Цалин урамшууллын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Наран-Учрал
Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Мөнх-эрдэнэ
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Бархасбадь

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Цалин урамшууллын хороо нь 2023 онд 2 удаа хурал зохион байгуулж, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах үүднээс “Түмэн шувуут” ХК-ийн “Цалин урамшууллын бодлого”-ыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан ба чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч чиглүүлэн ажилласан байна.

Тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлантай танилцаж, ажлын үр дүнтэй холбогдсон урамшууллын системийг илүү сайжруулах, цалин урамшууллыг бүтээмжтэй нь уялдуулах тал дээр зөвлөмж өгсөн.

Хүний нөөцийн тогтвортой байдлыг хадгалах үүднээс жил бүр ажилчдынхаа цалинг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлдэг бөгөөд 2023 оны тухайд цалингийн сангийн хэмжээ өмнөх оноос 30%-иар өссөн ба ажилчдын дундаж цалин 2,450,000 төгрөг байна.

Эдийн засгийн энэ хүнд цаг үед компани дотоод нөөц боломжинд тулгуурлан ажилчдын цалин, урамшууллын хэмжээг шат дараалалтайгаар нэмэгдүүлж, ажилчдын нийгмийн хангамжид дэмжлэг үзүүлж байгаа нь ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллахад маш чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Компанийн ажилчдыг хувьцаажуулах хөтөлбөрийг зогсоосон байсныг цаашид хэрэгжүүлэх, гэхдээ зөвхөн компанийн түлхүүр ажилчдын хүрээнд үргэлжлүүлэх нь зүйтэй гэсэн саналыг Цалин урамшууллын хорооны зүгээс гүйцэтгэх удирдлагад хүргүүлсэн.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ДАРГА.....Ц.НАРАН-УЧРАЛ

